

# НИЙСЛЭЛИЙН БАЯНГОЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН

## 2013 ОНЫ 03 ДУГААР САРД ХИЙСЭН АЖЛЫН МЭДЭЭ

2013.03.28.

Улаанбаатар хот

### Нэг. Удирдлага зохион байгуулалтын талаар

#### 1.1 Зохион байгуулсан ажлын талаар :

- Дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөн хуваарийн дагуу 3 дугаар сард 2 удаа зохион байгуулагдсан. Нийслэл, дүүргийн Засаг даргаас өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг нэгтгэж, [www.ulaanbaatar.mn](http://www.ulaanbaatar.mn) сайтад байршуулан ажилласан.

#### 1.2 Иргэдийн өргөдөл, санал хүсэлтийн талаар:

- Улаанбаатар сонсож байна “Цахим өргөдөл, гомдлын нэгдсэн систем” –ийг ашиглан өргөдөл, гомдлыг хүлээн авах, шилжүүлэх, шийдвэрлүүлэх, эргэн мэдээллэх үйл ажиллагааг удирдлагын заалтын дагуу зохион байгуулан ажиллаж байгаа бөгөөд дүүргийн Засаг даргын Тамгын газарт 2013 оны эхний 3 сарын байдлаар иргэдээс 313, албан хаагчдаас 33 нийт 346 өргөдөл, гомдол ирсэн байна.
- Баянгол дүүргийн хэмжээнд нийт өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдал 2013 оны 1 дүгээр улирлын байдлаар:

№	Байгууллага	Нийт	Шийдвэрлэх шатандаа		Шийдвэрлэж хариу өгсөн	
			Тоо	Хувь	Нийт	Хувь
1	Smartcity.mn	313	47	15%	266	85%
2	ЗДТГ	33	6	18%	27	82%
3	ХГХА	8650	731	8%	7919	92%
4	Хороод	5258	0	0%	5258	100%
5	<b>НИЙТ</b>	<b>14254</b>	<b>784</b>	<b>6%</b>	<b>13470</b>	<b>94%</b>

- Долоо хоног бүрийн 3 дахь өдөр Засаг даргын иргэд хүлээн авах уулзалтаар гарч буй иргэдийн гомдол, санал, хүсэлтийг тэмдэглэл хөтлөн шийдвэрлэлтэнд хяналт тавин ажиллаж байна. 2013 оны эхний 3 сарын байдлаар Засаг дарга нийт 138 иргэнийг хүлээн авч уулзаж, тэдний өргөдөл хүсэлтийг хүлээн авч шууд шийдвэрлэх боломжтой өргөдөл, гомдол, санал хүсэлтийг холбогдох мэргэжилтнүүдийг нь байлцуулан асуудлыг тухай бүрт нь шийдвэрлэн ажилласан.
- Төрийн дээд шагналаар шагнуулахаар ирүүлсэн 10 иргэний материалын бүрдлийг хангуулан хүлээн авч дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн

Тэргүүлэгчдийн хуралд танилцуулан тогтоол гарч, программд бүртгэн, зохих журмын дагуу албан тоотоор НЗДТГазрын шагналын асуудал хариуцсан мэргэжилтэнд шилжүүлсэн.

- “Алдарт эх” нэг, хоёрдугаар зэргийн одонгоор шагнагдах 286 эхчүүдийн материалын бүрдлийг хангуулан хүлээн авч дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлж, гарсан шийдвэрийг холбогдох материалын хамт Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн хурлын шагналын албанд хүлээлгэн өгсөн.

#### 1.3 Тайлан мэдээ, хугацаатай бичгийн шийдвэрлэлтийн талаар:

- 03 дугаар сарын байдлаар Засаг дарга, Засаг даргын Тамгын газарт нийт 240 албан бичиг ирсэн байна. Засаг даргын захирамж 45, Тамгын газрын даргын тушаал 30, албан бичиг 180 ширхэгийг тус тус бэлтгэн боловсруулсан байна.

#### 1.4. Төрийн албан хаагчдын үйл ажиллагааны талаар:

- Төрийн захиргааны 113 албан хаагчийн үр дүнгийн гэрээг нэгжийн менежертэй байгуулан батлуулсан.
- Төрийн захиргааны 14 албан хаагчийн албан тушаалын зэрэг дэв, түүний нэмэгдэл олгуулах саналыг УИХ-ын 199 оны 73 дугаар тогтоолын дагуу боловсруулан нийслэлийн Засаг даргын Тамгын газарт хүргэн, шийдвэрлэгдсэн.
- Төрийн жинхэнэ албаны шалгалт өгч тэнцсэн тус дүүргийн Засаг даргын Тамгын газрын 8 албан хаагч 03 дугаар сарын 12-ны өдөр Төрийн жинхэнэ албан хаагчийн тангараг өргөв.

#### 1.4.Хэвлэл, мэдээлэл, олон нийттэй харилцах ажлын хүрээнд:

- Дүүргийн Засаг даргын Тамгын газартай тогтмол харилцаж, мэдээлэл солилцдог 7 сонин, 8 вэбсайт, 10 телевизээр “Баянголчуудын бямба” их цэвэрлэгээний аян, “Олон улсын эмэгтэйчүүдийн баяр”, “Монгол цэргийн өдөр” –ийн баярын арга хэмжээнүүдийг иргэд, олон нийтэд хүргэж ажилласан.
- Дүүргийн facebook -ийг нээж, хөтөлсөн.

### **Хоёр. Эдийн засаг, төсөв, санхүүгийн бодлогын хүрээнд**

#### 2.1 Төсвийн орлогын талаар:

- Орон нутгийн төсвийн орлогоор 2013 оны 03 дугаар сард 2 тэрбум 68,6 сая төгрөг байхаар төлөвлөснөөс өнөөдрийн байдлаар 2 тэрбум 187,3 сая төгрөг төвлөрүүлж, төвлөгөөг 118,7 сая төгрөгөөр давуулж, 105,7% хувьтай явагдаж байна.

#### 2.2 Төсвийн зардлын гүйцэтгэлийн талаар:

- 2013 оны орон нутгийн төсвийн байгууллага 2,1 тэрбум, тусгай шилжүүлгээр 9,5 тэрбум төгрөгийн санхүүжилт олгогдсон. Төлбөр тооцооны мэргэжилтнүүд төсвийн байгууллагуудын нягтлан бодогч нартай хамтран 2013 оны эхний 3 сарын олгогдсон санхүүжилтийн хүрэлцээ төсвийн тооцоо хийж, өр авлага гарах эсэх талаар судлан ажиллаж байна.

### 2.3 Мэдээ, тайлангийн талаар:

- Нийслэлийн өмчийн харилцааны газартай хамтарч Төрийн болон орон нутгийн өмчийн эд хөрөнгийн тооллогын ажлыг дүүргийн хэмжээнд зохион байгуулж, 21 өрхийн эмнэлэг, 7 төр захиргааны байгууллага, 18 сургууль, 30 цэцэрлэг өмч эзэмшлийн гэрээг 100% байгуулж нийт 76 байгууллагын өмч, хөрөнгийн нэгтгэл хийж, Нийслэлийн өмчийн харилцааны газарт хүргүүлсэн.

### 2.4 Хөрөнгө оруулалт, төлөвлөлтийн талаар:

- Дүүргийн Засаг даргын Тамгын газрын ажилтан, албан хаагчид болон хороодын Засаг дарга нарыг хамруулсан “Олон нийтийн оролцооны аргаар хөрөнгө оруулалтыг төлөвлөх нь” сэдэвт сургалтыг 03 дугаар сарын 06-нд зохион байгуулсан.
- Нийслэлийн хөрөнгө оруулалтын газарт ирэх 3 жилийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг боловсруулан хүргэсэн.
- Дүүргийн хэмжээнд улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийгдэх ажлын төлөвлөгөөг нэгтгэн гаргасан.
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөр, арга хэмжээ, саналын талаар Засаг даргын Тамгын газар, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Ажлын Албатай хамтран 2013 оны 03 дугаар сарын 13-16 ны өдрүүдэд дүүргийн 23 хороонд зохион байгуулсан олон нийтийн санал асуулга, хэлэлцүүлгийн дүнд хороодын Засаг дарга нараас ирүүлсэн саналуудыг нэгтгэн дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралд өргөн мэдүүлсэн.
- ЭЗХЯ, ҮХААЯ, Хөдөлмөрийн яам, БХБЯ-ны хамтарсан ажлын хэсгийн удирдамжийн дагуу Монгол Улсын 2014-2016 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах төсөл, арга хэмжээний саналыг эрэмблүүлэх, дүүргийн иргэдээр хэлэлцүүлэн шууд санал хураалт явуулж эрэмбэлүүлэх ажлыг зохион байгуулж, нийт 23 хорооны иргэдийн саналыг авч нэгтгэлээ. Иргэдийн шууд санал хураалтаар хамгийн өндөр ач холбогдолтойгоор шалгарсан төсөл, арга хэмжээний талаар хурлын протокол үйлдэж, Дүүргийн ИТХ-ын даргын гарын үсэг бүхий албан бичгээр баримтжуулсан.

### 2.5 Гэр хороолол дахин төлөвлөлтийн талаар

- Улаанбаатар хотын гэр хорооллыг орчин үеийн барилгажсан хороолол болгон хөгжүүлэх нэгдсэн төлөвлөгөөний дагуу сонгосон гэр хорооллуудыг инженерийн болон бусад дэд бүтцийг цогцоор нь хөгжүүлэхэд дэмжих зорилгоор “Гэр хорооллын дахин төлөвлөлт” сэдэвт уулзалт-семинарыг 2013.03.07 зохион байгууллаа. Уулзалт-семинарт дүүргийн Удирдах ажилтнууд, нийслэлийн ерөнхий төлөвлөгөөний газар, нийслэлийн дэд бүтцийн хэлтэс, хороодын Засаг дарга нар оролцсон.

### 2.6 Худалдан авах ажиллагааг төлөвөлөх, зохион байгуулах талаар:

- Нийслэлийн төсвийн хөрөнгөөр хийгдэх, нийслэлийн Засаг даргаас дүүргийн Засаг даргад эрх шилжин ирсэн 2012-2013 он дамжин хийгдэх 1270,0 сая төгрөгний өртөгтэй 11 нэр бүхий ажлаас 5 ажилд нээлттэй тендер, 6 ажилд харьцуулалтын аргаар тендер зарласан. Үүнээс 1059,8 сая төгрөгний өртөгтэй 5 ажил гэрээ байгуулагдах шатандаа, үлдсэн 210,2 төгрөгний өртөгтэй 6 ажил тендер үнэлэх шатандаа явж байна.

- Улс, нийслэл, дүүргийн хөрөнгө оруулалтаар Баянгол дүүргийн Боловсорлын салбарт хийгдэх хөрөнгө оруулалтын ажлын дэлгэрэнгүй судалгааг гаргах зорилгоор сургууль, цэцэрлэгүүдээс дэлгэрэнгүй судалгааг 2013 оны 3 сарын 28-ний байдлаар авч нэгтгэж байна.

## 2.7 Бусад ажлын талаар:

- Орон нутгийн төсвт тодотгол оруулах асуудлыг дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн хуралдаанаар батлуулсан. Төсвийн тодотголоор орон нутгийн орлогыг 2 тэрбум 50,0 сая төгрөгөөр, зарлагыг 3 тэрбум 546,4 сая төгрөгөөр нэмэгдүүлж хуралдаанаар батлуулсан.
- Төсвийн тухай хуулийн 40.1-д заасны дагуу дүүргийн төсвөөс санхүүждэг төрийн болон төрийн бус өмчийн 109 байгууллагын төсвийн шууд захирагч нартай Дүүргийн Засаг дарга 2013 оны үр дүнгийн гэрээ байгуулах ажлыг зохион байгуулсан.
- Дүүргийн хэмжээнд 14706 аж ахуй нэгж байгууллагын тайлан хүлээн авахаас 11006 аж ахуй нэгж байгууллагын тайланг хүлээн авч, нэгтгэлийг 03 дугаар сарын 04-нд нийслэлийн Санхүү төрийн сангийн хэлтэст хүргүүлсэн.

## **Гурав. Үйлдвэрлэл үйлчилгээ, дэд бүтцийн салбарын бодлогын хүрээнд**

### 3.1 Байгаль орчин, орчны бохирдол, хог хаягдлын чиглэлээр:

- Баянгол дүүрэг нь Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах цогц арга хэмжээний хүрээнд түүхий нүүрсийг хязгаарлах хязгаарлалтын үндсэн бүсэд багтсан бөгөөд “Роял өүшин” ХХК-ний “Дөл” зуух, “Хүрд” ХК-ний Усан халаалтын нам даралтын зуух нийлүүлэгдэж байгаа бөгөөд 2013.03.20-ны өдрийн байдлаар 1397 өрх зуух авах захиалга өгч 2225 өрхөд зуух нийлүүлэгдсэн байна.
- Баянгол дүүргийн гэр хорооллын 9 хороонд нийт 12461 өрхөд боловсруулсан түлш түгээх цэгүүдээр дамжуулан 2013 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн байдлаар үртсэн шахмал түлш 2677.825 тн, хагас кокосжуулсан түлш 3950.144 тн нийт 6627.969 тн түлш хүлээж авч борлуулсан. Борлуулсан түлшний орлого 349,668,000/гурван зуун дөчин есөн сая зургаан зуун жаран найман мянган / төгрөгийг дансанд төвлөрүүлж Цэвэр агаарын санд тушаасан. Давхардаагүй тоогоор 7574 өрх буюу 61,0%-д нь боловсруулсан түлш хүрсэн.
- Дүүргийн хог хаягдлын оновчтой менежментийг хамтран хэрэгжүүлэх, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, шинэ мэдлэг, мэдээлэлтэй болох, багаар хамтран ажиллах зорилгоор хороодын Засаг дарга нар, хэсгийн ахлагч, тээвэрлэгч байгууллагыг хамруулсан сургалтыг 2013 оны 03 дугаар сарын 03-ны өдөр зохион байгууллаа.
- Агаарын бохирдлыг бууруулах ажлын хүрээнд эрчим хүчний хэмнэлтэй, бүрэн шаталттай сайжруулсан зуух борлуулах, түгээх ажлыг эрчимжүүлэх зорилгоор хязгаарлалтын үндсэн бүсэд хамрагдсан хороодын хэсгийн ахлагч нарын дунд 2013.03.01-нээс 2013.04.01-ний өдөр хүртэлх хугацаанд болзолт уралдаан зарласан.
- Хог тээвэрлэлтийн үнэ тарифыг шинэчлэн ДИТХ-ын Тэргүүлэгчдийн хурлаар батлуулж мөрдөн, нийтийн эзэмшил, орон сууц, гэр хорооллын айл

өрх, аж ахуйн нэгж байгууллагын хог хаягдлын төлбөр тооцоо болон хог тээвэрлэлтэд гарах аливаа харилцааг зохицуулахаар хог тээвэрлэлтийн шууд гэрээг аж ахуйн нэгж, байгууллагуудтай шинэчлэн хийж эхэлсэн.

- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2009 оны 63 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх, Дүүргийн хэмжээнд иргэдийг эрүүл, аюулгүй, цэвэр орчинд аж төрөх нөхцлийг бүрдүүлэх зорилгоор нийтийн эзэмшил, орон сууц, гэр хорооллын гудамж талбайд үүссэн хог хаягдал, цас мөс, хальтиргаа гулгаа, нийтийн өмчийн эд хөрөнгийг цэвэрлэх бүх нийтийн их цэвэрлэгээг долоо хоног бүр зохион байгуулж хэвших зорилгоор **“Баянголчуудын Бямба гариг”** их цэвэрлэгээний нээлтийг хийж иргэд, байгууллага, аж ахуйн нэгжүүдэд мэдээлэл хүргэх, сурталчилгааны самбаруудыг байршуулах, хэвлэл, радио телевизерээр сурталчлан Дүүргийн Засаг даргын 2013 оны 1/325 дугаар захирамжаар нийтийн их цэвэрлэгээг долоо хоног бүрийн Бямба гаригт 11.00-14.00 цагийн хооронд тогтмол зохион байгуулж байна.
- Баянгол дүүргийн Хөдөлмөрийн хэлтэстэй хамтран **“Эзэнтэй Монгол”** хөтөлбөрийн хүрээнд хороо бүрт орчны цэвэрлэгээ, үйлчилгээг хариуцсан 2-5 хүнийг нийтийн үйлчилгээний ажилтнаар урамшуулалтай ажиллуулж, дүүргээс хороо бүрийг цэвэрлэгээнд шаардлагатай багаж хэрэгсэл, тэрэг, чанга яригч, сурталчилгааны плакат материалаар хангасан.

### 3.2 Гэрэлтүүлгийн чиглэлээр:

- Нийтийн эзэмшлийн зам талбай, орон сууц, гэр хорооллын гэрэлтүүлгийн асалт, гэмтэл, засвар үйлчилгээнд засвар ашиглалтыг хариуцсан **“Цахилгаан тээвэр ХК”** -тай хамтран долоо хоног бүрийн **“Пүрэв”** гаригт тогтмол үзлэг хийж, засвар үйлчилгээг шуурхай хийлгэж байна.

3 сарын 18-ны байдлаар	НЭЗТ	Орон сууц	Гэр хороолол	Дундаж асалтын хувь
Асалтын хувь	<b>86.5%</b>	<b>86%</b>	<b>73.3%</b>	<b>81.9%</b>

### 3.3 Гадна зар сурталчилгааны байгууламжийн чиглэлээр:

- Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2013 оны 3/32 тоот тогтоолоор **“Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт гадна зар сурталчилгааны байгууламжийг байруулахад дагаж мөрдөх журам”**-ыг шинэчлэн баталж дээрхи байгууламжийг дүүрэг хариуцах үүрэг, хариуцлага шилжин ирсэн. Үүний дагуу зар сурталчилгааны байгууламжинд тооллого хийж журамд заагдсан байршилд гадна зар сурталчилгаа байршуулахыг хориглосон 30 газрын судалгааг гаргаж мэдэгдэх хуудас хүргүүлж, эхний шатанд хашаа хайс, явган хүний зам дагуу байршуулсан зар сурталчилгааны самбарыг албадан буулгах ажлын хэсэг байгуулж, бэлтгэл ажлыг хангаж байна.
- Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хэргийн гаралтыг бууруулах, илрүүлэлтийг нэмэгдүүлэх зорилгоор дүүргийн нутаг дэвсгэрт тавигдсан камерийн системийг тоолох, ажиллагааны бүрэн бүтэн байдлыг шалгах, эзэнжүүлэх, шинээр камержуулалт хийх байршлыг тогтоох ажлын хэсэг

дүүргийн Засаг даргын 2013 оны А/126 дугаар захирамжаар байгуулагдан ажиллаж байна.

#### 3.4 Дэд бүтэц, орон сууц, нийтийн аж ахуйн салбарын чиглэлээр:

- Шинээр ашиглалтад орсон болон харьяалалгүй орон сууцны сууц өмчлөгчдийн хурлын шийдвэр, холбогдох баримт бичгийг үндэслэн шинээр байгуулагдсан 5 СӨХ-г бүртгэн авч гэрчилгээ олгосон.
- Дүүргийн нутаг дэвсгэрт байгаа инженерийн шугам сүлжээний /дулаан, бохир, үерийн шугам, холбоо, цэвэр усны худаг/ тооллогыг 23 хороонд хийж эзэн холбогдогчдыг тогтоож засвар үйлчилгээ, тагжуулах ажлыг хийлгэж эхэлсэн.

#### 3.5 Худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний чиглэлээр:

- БГД-ийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа эрхэлдэг 54 дэлгүүрт 3 дугаар сарын 11-ний өдрөөс эхлэн “Нөөцийн мах” худалдаж эхэлсэн бөгөөд “Мах импекс” ХХК, “Мах маркет” ХХК, “Соён уул” ХХК-наас 26 тн нөөцийн махыг татан авч худалдаанд гаргасан байна.
- “Тамхины хяналтын тухай”, “Хүнсний тухай”, “Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай” хуулиуд нь 2013 оны 03 сарын 01-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан дүүргийн аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд хуулийг сурталчилах зорилгоор “Тамхины хэрэглээ-Хор уршиг” зурагт дэлгэмэл хуудас, “Утаат тамхи татахыг хориглоно” палкат зэргийг бэлтгэж хэвлүүлэв. Мөн Худалдаа, үйлчилгээ эрхлэгч нарт зориулсан хууль тогтоомжийн эмхтгэлийг нэгтгэж хэвлүүлэхэд бэлэн болоод байна.
- Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан 03 дугаар сарын 02-ны өдөр дүүргийн алдарт эхчүүд, эмэгтэйчүүдэд хүндэтгэл үзүүлэх 3000 ээжийн “БАЯНГОЛЫН ЭМЭГТЭЙЧҮҮД” хүндэтгэл үзүүлэх ёслолын арга хэмжээг UB паласын концертийн их танхимд зохион байгуулсан.

#### **Дөрөв. Боловсрол, соёл, эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлогын хүрээнд**

- Цусны донорын эгнээг өргөжүүлэх хүмүүнлэгийн сайн үйлсийн аянг орон даяар өрнүүлэх зорилгоор Монгол Улсын Ерөнхийлөгчийн ивээл дор зохион байгуулсан “Амьдрал бэлэглэе” аянд 03 дугаар сарын 15-нд тус дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх харъяа газар, хэлтэс, албадын нийт 234 ажилтан, албан хаагчид хамрагдсан.
- Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Малчдад туслах” аянд Засаг даргын Тамгын газрын ажилтан албан хаагчид оролцож нэг өдрийн цалингаа хандивласан.

#### **Тав. Цэрэг, иргэний хамгаалалтын талаар**

##### 5.1 “Монгол цэргийн өдөр”-ийг тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд:

- Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабаас 2013 оныг “Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлах, төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх жил” болгон дэвшүүлсэн зорилтын хүрээнд дүүргийн Засаг даргын захирамжаар

батлагдсан “Монгол цэрэг”-ийн өдөр, Зэвсэгт хүчний 92 жилийн ойн ажлын төлөвлөгөөний дагуу 2013 оны 02 дугаар сарын 25-28-ны өдрүүдэд хороодод ажиллаж, хаалтын ажиллагааг 02 дугаар сарын 28-ны өдөр дүүргийн “Оюуны ундраа” цогцолбор сургуулийн урлаг зааланд “Батлан хамгаалах хууль тогтоомжийг сурталчлан төрийн үйлчилгээг иргэдэд хүргэх нь бидний ажил” сэдэвт ажлаа сурталчлах өдөрлөгийг зохион байгуулсан.

- Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 92 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх арга хэмжээний хүрээнд Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын төлөвлөгөөгөөр 2013 оны 03 дугаар сарын 02-нд нийслэл, дүүргийн Цэргийн штабын офицеруудын дунд зохион байгуулсан гар буу, хөгжилтэй буухиа, гар бөмбөгийн тэмцээнд Цэргийн штабын хамт олон “Дуулга” нэртэйгээр баг болон оролцож, гар бөмбөгийн төрөлд 2 дугаар байр эзэлсэн.
- 2013 оны 03 дугаар сарын 09-нд дүүргийн Засаг даргын нэрэмжит боулингийн тэмцээнийг зохион байгуулж, ЗДТГ-ын албан хаагчид бүрэлдэхүүнээрээ оролцсон.
- Дүүргүүдийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд танин мэдэхүйн “АХА”, “Дөл”, “Монгол цэргийн жавхаа” сэдэвт зохион бичлэгийн уралдаан, тэмцээнүүдийг Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабтай хамтран зохион байгуулав.
- Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын төлөвлөгөөгөөр 03 дугаар сарын 12-нд зохион байгуулагдсан билльард, боулингийн тэмцээнд Цэргийн штаб багаараа оролцсон.
- Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 92 жилийн ойн нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын төлөвлөгөөний дагуу 03 дугаар сарын 14-нд Соёлын төв өргөөнд нийслэлийн 3 үеийн уулзалт цэнгүүнд тус дүүргийн ЕБС-ийн 100 сурагч, хороодоос 150 иргэнийг оролцуулж, Цэргийн штаб иргэдэд ажлаа сурталчлан 25 иргэний асуудлыг шийдвэрлэсэн.
- 03 дугаар сарын 17-ны өдөр UB palace-ийн концертийн их танхимд дүүрэгт амьдардаг генерал цолтнууд болон 23 хорооны иргэдийн төлөөллийг хүлээн авч, ёслол, хүндэтгэлийн арга хэмжээг зохион байгуулсан.

## 5.2 Бусад төлөвлөгөөт ажил:

- Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын даргын 2013 оны А/12 дугаар тушаал, дүүргийн Засаг даргын 2013 оны А/127 дугаар захирамжаар хорооны Засаг дарга нарын 2013 оны цэргийн бэлтгэл сургалтыг 2013 оны 03 дугаар сарын 21-23-ны өдрүүдэд зохион байгуулсан.

ХЯНАСАН:

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН

ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ

М.БАДРАХ

МЭДЭЭ ГАРГАСАН:

ЗАХИРГАА, ХУУЛИЙН

ХЭЛТСИЙН МЭРГЭЖИЛТЭН

П.АНХТУЯА